

МОНГОЛ-ТАЙВАНИЙ СОЁЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Д.Золбоо**

Хэдхэн жилийн өмнө жирийн монголчуудын хувьд огт мэддэгүй шахам байсан “Тайвань” гэдэг нэр өнөөдөр мэдээлэл харилцаа хөгжсөн, даяаршлын эрин зуунд амьдарч буй монголчуудын хувьд тийм их хачирхалтай санагдахаа больсон ажээ.

Гадаад бодлогынхоо хүрээнд дэлхийн олонх улс гүрний нэгэн адил “нэг Хятад” гэсэн байр суурийг баримталдагынхаа хувьд Монгол Улс Тайванийг тусгаар тогтносон улс гэж үздэггүй бөгөөд БНХАУ-ын явуулж буй “энх тайвнаар нэгтгэх”, “нэг улс, хоёр систем”-ийн чиг бодлогыг дэмжиж ирсэн түүхтэй. Энэ талаар Монгол Улс, БНХАУ-ын хооронд дээд хэмжээнд удаа дараа мэдэгдэл¹ гарч байсан.

Хоёр талын харилцааны талаар тусгайлан судалсан бүтээл манайд хараахан гараагүй байгаа хэдий ч судлаач нар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлсэн өгүүлэл, нийтлэлүүд мэр сэр гаргасаар ирлээ. Харилцааны түүхийг ерөнхийд нь 1990-ээд оноос өмнөх болон хойших гэсэн 2 үндсэн хэсэгт хуваан үзэж болох юм.

Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар 1945 онд байгуулсан Зөвлөлт-Хятадын найрамдлын гэрээний хавсралтын дагуу² БНМАУ-д болсон бүх нийтийн санал хураалтын дүнд үндэслэн манай улсыг олон улсын субъектийн хувиар хамгийн түрүүнд хүлээн зөвшөөрсөн улсын нэг нь Дундад Иргэн Улс билээ. Хоёр орны хооронд 1946 оны 2 дугаар сарын 13-нд дипломат харилцаа тогтоосон³ боловч 1949 оны 10 дугаар сарын 16-нд манай улс БНХАУ-ыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоогоод Дундад Иргэн Улстай харилцаа тасарчээ. 1954 оны 12 дугаар сард Дундад Иргэн Улс, АНУ-тай Харилцан хамгаалах хэлэлцээр (Mutual Defence Treaty) байгуулахад урьд ЗХУ-тай байгуулсан Найрамдлын гэрээ хүчингүй болж, тэдний зүгээс Монголыг тусгаар улс гэж үзэх үндэслэл нь хамт үгүй болжээ. Ингэснээр Үндсэн хуулиндаа Монголыг өөрийн нутаг дэвсгэрийн салшгүй хэсэг гэж үздэг 1945 оны өмнөх заалт өөрсдийнх нь хувьд сэргэсэн түүхтэй ажээ.⁴

1946-1990 оны хооронд улс төрийн хоёр туйлт дэлхий ертөнцийн эсрэг тэсрэг талд харьяалагддагынхаа хувьд бие биенийхээ тусгаар тогтнолыг үгүйсгэн буруутгахаас өөрөөр бодит байдал дээр харилцаж байсангүй.

Харин 1990-ээд оноос эхлэн манай шинжлэх ухаан, боловсрол, хүмүүнлэг, эрүүлийг хамгаалах салбарт буцалтгүй тусламж үзүүлэх, эдийн

* Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

засгийн салбар, иргэд хоорондын харилцаа, жуулчлалаар харилцан түүх соёл, ахуй амьдралыг сурталчлах зэрэг ажлыг зохион байгуулж иржээ.

1992 оны 4 дүгээр сарын 30-нд Тайваний Ерөнхийлөгч Ли Дэньхуй нэгэн хэвлэлийн бага хурал дээр Тайвань нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч байгаа гэж зарласан нь тухайн үедээ багагүй шуугиан тарьсан бөгөөд тэр үеийн гадаад, дотоодын хэвлэлээр нэлээд шуугиж байжээ. Тайваний зүгээс сүүлийн жилүүдэд өөрийн бодлогоо бодит байдалд нийцүүлэх, улмаар Монгол Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх үүднээс Үндсэн хуулиндаа Монгол Улсыг өөрийн газар нутгийн нэг хэсэг гэсэн заалтаасаа татгалзсан зарчмын чанартай өөрчлөлт оруулах, Монгол Улсын нэрийг зөвөөр хэрэглэх, өөрсдийн хэрэглэж буй дэлхийн улс төрийн газрын зургаа өөрчлөн засч хэвлүүлэх, Монголоос ирж буй аливаа хүнд бусад орны жишгээр албан ёсны виз олгож нэвтрүүлдэг болсон, Монгол орны талаар өөрсдийн олон нийтэд сурталчлан таниулах гэх мэт нэлээд өөрчлөлт хийжээ.

Энэ хугацаанд дээрх салбаруудыг хамарсан үйл ажиллагааны ихэнхийг Монголын талаас Далайн орнууд, бүс нутагтай эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх Монголын нийгэмлэг (төрийн бус байгууллага) харин Тайваний талаас төрийн байгууллага болох Монгол, Төвдийн хороо болон түүний дэргэдэх Дэлхийн Монголчуудын холбоо, Тайваний Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн сан (Taiwan ICDF) зэрэг байгууллага голлон зохион байгуулж иржээ. Мөн олон жилийн өмнө эх нутгаасаа дүрвэн гарч, Тайваньд очсон монгол гаралтай хувь хүмүүс ч гэсэн иргэд хоорондын харилцаа холбоог хөгжүүлэхэд тодорхой хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Энд сүүлийн 15 жилийн хугацаанд болсон соёл, боловсрол, эдийн засаг, хүмүүнлэгийн харилцааны холбогдолтой зарим мэдээллийг мэдээ баримт дээр тулгуурлан хүргэж байна.

Боловсролын салбарт:

Энэ салбарт голчлон Тайваний талаас хөрөнгө гаргаж судлаач, эрдэмтэд солилцох, хятад хэлний мэргэжил дээшлүүлэгчдийг сургах, хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохиох зэрэг ажлыг хийж иржээ.

Анхлан Тайваний талаас зардлыг нь гаргаж Монголын 10 багшийг АНУ, ХБНГУ, ИБУИНВУ-д англи хэлний 1 жилийн сургалтанд хамруулж байсан. Түүнээс гадна сүүлийн 15 жилд 100 гаруй залуусыг өөрийн их, дээд сургуулиудад хятад хэлний мэргэжил дээшлүүлэх 1 жилийн сургалтанд хамруулжээ. 2003 оноос Тайваний зүгээс зөвхөн хэлний мэргэжил дээшлүүлэх болон бусад богино хугацааны сургалтаас гадна жил бүр 20 монгол залууст өөрсдийн сургуулийн магистр, докторын сургалтад хамрагдах тэтгэлэг олгож эхэлсэн нь манай боловсролын салбарт хийж буй томоохон хөрөнгө оруулалт болж байна. Мөн оноос

жил бүр Монголд өөрийн эх орондоо төрөл бүрийн мэргэжлээр амжилттай суралцаж буй 55 оюутан тус бүрд нэг удаагийн тэтгэмж болгон 450 ам.доллар олгох ажил уламжлал болж байна. Монголын их дээд сургуулиудтай хамтран ажиллах төслийн хүрээнд мэдээлэл, технологийн чиглэлээр дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, олон тооны компьютер, бусад техник хэрэгсэл хандивлаж байна.

Соёлын салбарт:

Монголоос Тайваний зардлаар Үндэсний дуу бүжгийн чуулга, “Түмэн эх” зэрэг чуулгын урлаг соёлын төлөөлөгчдийг урьж тоглолт хийлгэх, ардын урлаг, циркийн жүжигчдийг Тайваний хотуудаар аялан тоглуулах ажлыг хэд хэдэн удаа зохиожээ.

Уламжлал, соёлоо дэлгэрүүлэх, хадгалан үлдэх зорилгын үүднээс Монгол Улсын Засгийн газраас 1990-ээд оны эхээр уйгаржин монгол бичгийг төрийн албан ёсны бичиг болгохоор зарласны дагуу Тайваний зүгээс энэ ажлыг дэмжих зорилгоор төрөл бүрийн сурах бичиг, толь бичиг хэвлүүлэх болон тусгайлан зохиолгосон цахим бичгийн машиныг албан байгууллагуудаар тараах зэрэг ажилд 1992-1996 оны хооронд 1 сая орчим ам.долларын тусламж үзүүлсэн байна.⁵

Тайвань дахь Монгол судлал ч гэсэн өөрийн онцлогтой. Хэдийгээр зарим талаар “хятад төв”-ийн үзлээр Монгол үндэстний түүх, соёлыг гуйвуулан тайлбарлах хандлага байсаар ирсэн хэдий ч Монгол судлалын хөгжлийн төвшнөөр Ази тивдээ Япон, Хятадын дараа орох дэлхийд танигдсан олон сайн судлаачид, тэдний шинэ үе өнөөдөр ч гэсэн судалгаа шинжилгээний ажлаа хийсээр байна.⁶ Тайваний анхны монгол судлаачдын тоонд Японд их дээд сургууль төгссөн Өвөр Монгол сэхээтнүүд болох Хангины Гомбожав, Онон Өргөнгөө, Захчид Сэцэн, Харнууд Хаанчулуу, Дэдүл Жаргалан, Үнэнбуян, Хасчулуун, Сагарайжав, Өнийн-Урт нарыг нэрлэж болно.

Нүүдэлчин ард түмний эртний түүхэнд холбогдох олон тооны эртний сурвалж бичгүүдийг өөртөө хадгалж байгаагынхаа хувьд Монгол судлал тэр дундаа манай эртний түүх судлалд цаашдаа ч гэсэн олон сайн судалгааны бүтээл гарах бололцоотой юм. Тухайлбал, зарим түүх судлаачдын баталж буйгаар Монголын их эзэн Чингис хааны болон түүний угсаа залгамжлагчдын эх зургууд гэж тооцогддог бүтээл өнөөдөр Тайвань дахь Хааны ордон музейн сан хөмрөгт хадгалагдаж байдгийг дурьдаж болох юм. Сүүлийн жилүүдэд энэ салбарт хоёр талын түүхийн судалгаа, архивын байгууллагууд хамтран ажиллаж түүхийн холбогдолтой бичиг баримт солилцох, хамтран эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэрэг ажлыг хийж байна. Сүүлийн арав гаруй жилд Тайвань дахь Монгол судлалд өмнөх үетэй харьцуулахад нилээд өөрчлөлт гарсан байна. Өмнө нь, Монголын түүх, нэн ялангуяа Юань,

Чин улсын үеийн түүхэнд судалгаа голлон чиглэдэг байсан бол 1990 он гарсаар орчин үеийн Монгол Улс, улс төрийн шинэчлэл, эдийн засгийн өөрчлөлтөд ихээхэн анхаарал тавьж судалгаа хийх болжээ.

Монголын Хөрөнгийн бирж, их дээд сургуулиуд, Стратеги судлалын хүрээлэн, Монгол хятад судлаачдын холбоо, Үндэсний олимпын хороо, “Монголын рашаан сувилал” нийгэмлэг зэрэг олон байгууллага ижил төрлийн байгууллагуудтай туршлага солилцох, хамтарсан бэлтгэл сургуулилалт, эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлэх зэргээр хамтран ажиллаж байна.

2004 оны 2, 3 дугаар сард Монголын кино наадам Тайбэй, Гаошунь хотод зохиогдож манай уран сайхны хуучны болон сүүлийн үеийн шинэ 8 киног хятад хэл дээр орчуулгатай үзүүлж тайваний үзэгчдэд сонирхуулжээ. Мөн оны 5 дугаар сард Улаанбаатар хотод Тайваний кино өдрүүд зохиогдож олон бүтээл монголын үзэгчдийн хүртээл болгожээ.

Тайваний тал өөрийн зардлаар Монголын хэвлэл мэдээллийн төлөөлөгчдийг урьж өөрийн орноо монголчуудад сурталчлах ажлыг хийж ирсэн бөгөөд үүний дотор “Өнөөдөр” сонины “Тайфунтай аялал” цуврал нийтлэл, 25 дугаар суваг телевизийн “Үүргэвчтэй аялал” зэрэг нэвтрүүлгүүд уншигч, үзэгч олны хүртээл болсон.

Хүмүүнлэг, тусламжийн салбарт:

Тайвань нь харилцааны эхний үеэс л хүмүүнлэг, эрүүл мэндийн салбарт олон талын тусламж, дэмжлэг үзүүлж ирсэн. Дөнгөж зах зээлийн харилцаанд хөл тавин хүнсний барааны хомсдолд нэрвэгдэж байх 1990-ээд оны эхээр олон тонн гурил, цагаан будаа зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг Улаан загалмай зэрэг олон улсын тусламжийн байгууллагын шугамаар Монголын ард түмэнд ирүүлж байсныг олон хүн мэднэ. Түүнчлэн өөрийн зүгээс жил бүр Монголын хүүхэд асран хүмүүжүүлэх төв зэрэг олон байгууллагын хүүхэд багачуудад буяны гараа сунгаж дэмжин тусалж байдаг монгол гаралтай өндөр настан Чимидцэрэн зэрэг олон хүний нэрийг дурьдаж болно. Энд нэг зүйлийг сонирхуулахад, 1949 онд Өвөр Монголоос Тайваньд нийт 700 орчим⁷ хүн нүүдэллэн очсон бөгөөд одоогийн байдлаар монгол гаралтай 400 гаруй хүн байдаг байна.⁸ Энэ нь анх очсон монголчуудын олонх нь барууны орнуудад цагаачлан гарсан болон монгол хэл, соёлоо мэддэг хүний тоо цөөрсөнтэй холбоотой ажээ.

Мөн Тайваний Цучи шашны байгууллага болон бусад буяны байгууллагаас Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж болгон 200 гаруй тэргэнцэр бэлэглэжээ.

Тайбэй хотын захиргаанаас зохион байгуулан Хөдөлгөөнт эмнэлэг төслийн хүрээнд Тайваниас 20 орчим хүний бүрэлдэхүүнтэй нарийн мэргэжлийн эмч, сувилагч нарын баг 2004 онд Сэлэнгэ, 2005 онд

Дундговь аймаг, Улаанбаатар хотын Банязүрх, Сонгинохайрхан дүүргийн эмнэлэгт богино хугацаагаар ажиллаж өндөр настан, хүүхэд багачууд зэрэг хүмүүст нэг удаагийн үнэгүй үзлэг хийж эм тараасан байна. Мөн 2005 оны хавар Монголын шүдний эмч нарын холбоотой хамтран Улаанбаатар хотын дүүргүүдийн 6 сургуулийн хүүхдүүдэд шүд амны хөндийн өвчлөлийн судалгаа хийж тэдгээр сургуулиудад шүдний эмчилгээний кабинет бэлэглэсэн.

2001-2005 оны хооронд Тайваний Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн сан Монгол дахь Дэлхийн Зөн олон улсын тусламжийн байгууллагаар дамжуулан нэг хүүхдэд жилийн 100 ам.доллар олгож байгаа нь 400 мянган ам.долларт хүрчээ. Энэ мэт хүмүүнлэгийн салбарт хийсэн буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтын тоог нарийвчлан гаргавал нэлээн урт жагсаалт болно.

Эдийн засгийн салбарт:

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн харилцаанд суралцаж байсан монголчуудад зориулан гадаад худалдаа, олон улсын эдийн засгийн чиглэлээр сургалт явуулах, хөрөнгө оруулалт, жижиг дунд үйлдвэрийн асуудлаар уулзалт, хурал зохион байгуулах зэрэг олон талын үйл ажиллагааг явуулж иржээ. Үүний дагуу Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Аялал жуулчлалын холбоо, Жижиг дунд үйлдвэрийн нэгдсэн холбоо, Монголын Зам барилгын инженерүүдийн нийгэмлэг зэрэг төрийн бус олон байгууллага Тайваний ижил төрлийн байгууллагуудтай харилцаа холбоотой ажиллаж байна. Тухайлбал, 2005 он хүртэл Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Тайваний Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн сантай хамтран 4 удаагийн хамтарсан хуралдаан Улаанбаатар, Тайбэй хотод зохиож байсан бөгөөд хоёр талаас ажил хэрэгч хүмүүс оролцон Монголын эдийн засгийн байдал, бизнесийн орчин, хөдөө аж ахуй, хүнсний аж үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулах боломж, гадаад худалдаа, Монголын аялал жуулчлалын зах зээл, хөрөнгө оруулалтын туршлагын талаар мэдээлэл солилцож байжээ.

2002 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотод Тайбэйн худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн газар, 2003 оны 2 дугаар сард Тайбэй хотод Улаанбаатарын худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн газрууд харилцан нээсэн нь энэ салбарт хамтран ажиллах өргөн бололцоог олгож байна. Энэ хугацаанд хоёр талын хооронд худалдаа, эдийн засаг, соёл боловсрол, хүмүүнлэгийн салбар дахь солилцоо хамтын ажиллагаа улам бүр хөгжин түүнд оролцогчдын хүрээ тэлж, цаашид өргөжих төлөвтэй байна.

“Тайвань-Монголын соёл, эдийн засгийн солилцооны наадам”-ын хүрээнд хоёр талын худалдаа, эдийн засгийн семинар Тайбэй хотноо

2004 оны эхээр болж эдийн засгийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын талаар мэдээлэл солилцсон байна.

2004 онд Тайваний Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн сангийн шугамаар өрхийн аж ахуйг хөгжүүлэх, сургалт семинар явуулах, Европын сэргээн босголт хөгжлийн банкин дахь Монгол дахь хамтын ажиллагааны санд 1 сая еврогийн тусламж үзүүлэх, бизнес эрхлэгчдэд сургалт зохион байгуулах, Хас банкны шугамаар 3 сая ам.долларын жижиг зээлийн төсөл хэрэгжүүлэхээр тохиролцжээ. Хоёр талын банк хоорондын хамтын ажиллагаанд ахиц гарч Монголын “Голомт” банк, Тайваний “Эксим” банк, “Лэнд” банкны хооронд зээлийн хэлэлцээр байгуулагдсан ба “Эксим” банк Монголын компаниудад Тайваниас машин, тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 1.850 мянган ам.долларын зээлийг манай “Худалдаа хөгжлийн” банк, “Голомт”, “Анод” банкуудаар дамжуулан олгох, “Капитал” банк Монголд хэвлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэх Тайваний компанид 330 гаруй мянган ам.долларын аккредитив данс нээх зэрэг хэлбэрээр хамтран ажиллаж байна.

Өнөөдөр Монгол Улс дахь Тайваний хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо 34 болж хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 11 сая орчим ам.долларт хүрчээ. 2003, 2004 онд Улаанбаатар хотноо зохиогдсон “Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, технологи”, 2004, 2005 оны “Улаанбаатар түншлэл”, 2005 оны “Мэдээллийн технологи” сэдэвт олон улсын үзэсгэлэн худалдаанд Тайваний TAIFRA болон бусад үйлдвэр, худалдааны төлөөлөгчид өөрсдийн бүтээгдэхүүний дээж үзмэр, үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэлтэйгээр идэвхтэй оролцож иржээ. Хоёр талын гадаад худалдааны эргэлт байнга өсөн нэмэгдэж байгаа бөгөөд өнгөрсөн 2004 оны жилийн эцсийн дүнгээр хоёр талын худалдааны эргэлт 5 сая орчим ам.долларт хүрсэн бөгөөд үндсэндээ энэ нь Тайваний экспортоос бүрдэж байна.⁹

	2001	2002	2003	2004
Хоёр талын худалдааны нийт эргэлт (сая ам.доллар)	2.0	4.4	1.9	5.0

Эх сурвалж: Статистикийн эмхтгэл 2004

Тайваниас Монголд ирэх замын зардал өндөр байдгаас жуулчлалаар ирэх хүний тоо бага байдаг хэдий ч өнгөрсөн жил ирсэн жуулчдын тоо мэдэгдэхүйц өссөн байгаа нь цаашдаа Монгол орны байгаль орчин, түүх, ёс заншил, соёлын холбогдолтой сурталчилгааны ажлыг сайжруулж чадвал энэ тоо нэмэгдэх бололцоотойг харуулж байна.

1998 онд Улаанбаатар, Тайбэй хотуудын хооронд хамтын ажиллагааны гэрээ байгуулан ах-дүү хотын харилцаа тогтсон.

Олон жилийн турш яригдаж ирсэн Монголоос Тайваньд ажиллах хүч гаргах ажил хоёр тал идэвхийлэн хөөцөлдсөний үр дүнд Тайваний тал

Монголоос ажилчид авах албан ёсны шийдвэрээ 2004 оны 1 дүгээр сарын 17-нд зарлаж хэвлэлийн бага хурал хийсэн. Үүний дагуу Монголоос гаргах ажилчдын сургалт, эрүүл мэндийн үзтэг шинжилгээний ажилд Тайваний талаас 147 мянган ам.долларыг буцалтгүй тусламжийн хэлбэрээр гаргасан байна.

Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Зуучлах товчооны шугамаар Монголоос 10.000 хүртэл монгол иргэнийг Тайваньд ажиллуулахаар харилцан тохирч, бүртгүүлж, шалгуурт тэнцсэн эхний 175 хүнийг 2004 онд явуулсны 95 нь эрүүл мэнд, ар гэрийн гачигдал, сэтгэл зүйн бэлтгэлгүй байдал зэрэг янз бүрийн шалтгаанаар эх орондоо буцаж, 2005 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар 80 ажилчин ажиллаж байгаагийн дотор гэрийн асрагч 49, үйлдвэрийн ажилчин 31 байна. Тэдний нэг сарын цалин нь байр хоолны зардлаас гадна 500 орчим ам.доллар байдаг ажээ¹⁰. Монгол залуучууд Тайваньд очиж ажиллах сонирхол багатай байгаа нь цалин, ажлын хүнд бэрхээс гадна цаг агаар, хэл, ёс заншлын нэлээд зөрүүтэй байдагтай холбож тайлбарлаж болох юм.

Ази, Номхон далайн эдийн засагт жинтэй байр суурь эзэлдэг Тайваньтай худалдаа, эдийн засаг, хүмүүнлэгийн харилцаатай байх нь манай оронд олон талын ашигтай юм. Тайваньтай хэлхээ холбоо тогтоож түүнийгээ өргөжүүлж буй төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн тоо өсөн нэмэгдэж тэдний үйл ажиллагаа идэвхжих хандлагатай байна.

Тайваний зүгээс манай талаас аль болох өндөр албан тушаалтныг урьж айлчлуулах, яриа хэлцээ хийх, өөрийн талаас өндөр албаны хүмүүсээ манайд ирүүлэх сонирхолтой байдаг. Тайваньтай харилцах асуудал нь манай хувьд Монгол-Хятадын харилцаатай нягт холбоотой өнөө ба ирээдүйн эмзэг асуудлуудын нэг мөн тул гадаад бодлогын хүрээнд цаашид зөв зүйтэй нэгдмэл бодлоготой үйл ажиллагаа явуулах нь чухал. Энэхүү бодлогыг Монгол Улсын Гадаад хэргийн яам хэрэгжүүлж байгаа бөгөөд төрийн аливаа төвшинд харилцах асуудлыг бүхэлд нь зохицуулж байгаа хэдий ч тэр бүр хяналт тавьж чаддаггүй нь бас харагддаг.

БНХАУ-ын судлаач Ли Дазунь нарын эрдэмтэд “Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлого Хятадын аюулгүй байдалд нөлөөлөх нь” гэсэн өгүүлэлдээ Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд нэг хятад зарчмыг баримталж Тайваний тусгаар тогтнолыг дэмждэггүй, үүний зэрэгцээ Тайваньтай харилцах харилцаагаа бүрмөсөн таслах сонирхолгүй байдаг. Энэ нь Монгол, Тайваний харилцаа ялангуяа худалдаа, эдийн засгийн харилцаа цаашид үргэлжлэх боловч чанарын хүчтэй өөрчлөлт гарахгүй гэдгийг харж болно¹¹ гэж дүгнэсэн нь бодит байдалд нийцсэн дүгнэлт гэж хэлэх нь зүйтэй.

2005 оны 3 дугаар сард БНХАУ-ын Ардын төлөөлөгчдийн их хурлын 10 дахь удаагийн сонгуулийн 3 дугаар чуулганаар “Салан

тусгаарлахын эсрэг хууль” баталсан нь Тайваний хоолойн бүс нутагт улс төрийн нөхцөл байдлыг хөндсөн ноцтой алхам болсон юм. Уг хууль батлагдсаны дараахан АНУ, Канад, Европын Холбоо зэрэг томоохон гүрнүүд ийм хууль батлагдсан сэтгэл түгшиж байгаагаа илэрхийлж байжээ.

БНХАУ-тай хил залгаа, хөрш орны хувьд Тайваний хоолой орчмын улс төрийн үйл явц манай орны эрх ашгийг хөндөх асуудлын нэг мөн бөгөөд Монгол Улс түүнд анхаарлаа зайлшгүй хандуулж байр сууриа тодорхойлж байх нь ойлгомжтой. 2005 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн Монгол Улсын Гадаад хэргийн яамны хэвлэлийн төлөөлөгчийн мэдэгдэл “Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын 10 дахь удаагийн сонгуулийн 3 дугаар чуулганаар “Салан тусгаарлахын эсрэг хууль” баталжээ. Энэ нь БНХАУ-аас баримталж ирсэн эх орноо энх тайвнаар нэгтгэх “нэг Хятадын” бодлоготой холбоотой гэж ойлгож байна. Уг асуудлаар манай байр суурь тодорхой. БНХАУ-ын эх орноо энх тайвнаар нэгтгэх бодлогыг Монгол Улс дэмжсээр ирсэн бөгөөд манай байр суурь цаашид ч хэвээр байх болно.” гэж дурьджээ. Энэ мэдэгдлээс үзэхэд Монгол Улсын Засгийн газар “Салан тусгаарлахын эсрэг хууль”-ийг шулуухан дэмжихсэн гэж хэлэх нь учир дутагдалтай.

Хэдийгээр энэ асуудал БНХАУ-ын дотооддоо шийдэх асуудал мөн боловч түүнийг энхийн, тайван замаар шийдвэрлэх нь бүс нутгийн төдийгүй дэлхийн энх тайван, тогтвортой байдалд чухал ач холбогдолтой юм.

Ашигласан материал:

1. Гадаад хэргийн төрөлжсөн архив. х-5, д-1, хн-660, хн-663
2. М.Батчимэг, “Орос-Хятадын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. нэгдүгээр хэсэг 1689-1949” УБ. 2001 280-р тал
3. БНМАУ-ын түүх, III боть, УБ. 1969. 512-р тал
4. Гадаад хэргийн төрөлжсөн архив. х-5, д-1, хн-6328 хуудас 2
5. Монгол, Төвдийн хорооны 1998 оны судалгааны тайлангийн нэгдүгээр өгүүллийн хавсралтаас
6. “Тайвань дахь Монгол судлал” Олон улс сэтгүүл, 2002. №4
7. Харнууд Хаанчулуу. Шоовдорлогдсон монгол судлал, Монголика сэтгүүл 1992 Улаанбаатар
8. Лан Мэйхуа, “Тайваньд 400 гаруй монгол гаралтай хүн байдаг” Өнөөдөр сонин, 2005 №39
9. Үндэсний Статистикийн Газар. “Статистикийн эмхтгэл 2004”, УБ. 2005
10. Д.Бэхбаяр, “Тайфунтай аялал” Өнөөдөр сонин 2005.02 сар
11. “Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлого Хятадын аюулгүй байдалд нөлөөлөх нь” ОУС сэтгүүл, УБ 2005 №3